# АВТО ЗАМЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2019.12.27. Улаанбаатар хот

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 259 дүгээр тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг тус тус баримталсан.

## Хоёр. Танилцуулга

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус газраас ирүүлсэн тайлан, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, Засгийн газар, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт, Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт, Зам, тээврийн хөгжлийн Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Ил тод байдлын үнэлгээг үндсэн материал болгон ашигласан.

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ ажил, үйлчилгээний 195 арга хэмжээний хүрээнд авч үзлээ.

Тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар дүгнэснийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №1

| № | Бүтээгдэхүүн | Ажил, үйлчилгээний тоо | Хэрэгжилтийн түвшин | | | | | Биелэлтийн дүн / % / |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 % | 70 % | 30% | 0% | Хугацаа болоогүй | |
| 1 | Нийт ажил, үйлчилгээ | 195 | 136 | 29 | 30 | - | - | 84.8 |
| | **Бүгд** | **195** | **136** | **29** | **30** | **-** | **-** | **84.8** |

Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг шалгахад нийт 195 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 100%-ийн биелэлттэй 136, 70%-ийн биелэлттэй 29, 30%-ийн биелэлттэй 30 арга хэмжээ байгаа ба гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт нь 84.8 хувьтай байна.

**Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн 30 арга хэмжээ нь:**

| № | Зорилтот түвшин | Арга хэмжээний нэр | Биелэлт |
|---|---|---|---|
| **Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн 29 арга хэмжээ нь:** | | | |
| 1 | 3.3. “Авто замын барилга, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, технологийг шинэчлэх, аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, дэмжлэг үзүүлэх” гэсэн зорилтын хүрээнд | 3.3.15 Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох авто зам 1 дүгээр багц-120 км.<br><br>Барилгын ажлыг эхлүүлсэн байна.<br><br>2-4 улирал | Зам барилгын ажлыг эхлүүлэх 06/18/2017 дугаартай зөвшөөрлийг 2017 оны 12 дүгээр сарын 26-ны өдөр олгосон.<br>Концесс эзэмшигчээс далан, ухмал, хиймэл байгууламжийн ажил гүйцэтгэж байгаа бөгөөд ойролцоогоор нийт ажлын 20%-ийг хийж гүйцэтгэсэн талаар Үндэсний хөгжлийн газарт мэдээ өгсөн боловч эдгээр ажил нь Зөвлөхөөр баталгаажаагүй байна.<br>Үүнтэй холбоотой шалгах ажиллагааг эрх бүхий байгууллагаас хийж байна. |
| 2 | | 3.3.17 Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай авто зам барих. | 2017 онд концесс олгох уралдаант шалгаруулалт зарласан боловч санал ирээгүй тул хуулийн дагуу шууд гэрээний нөхцөл үүссэн. |
| 3 | | 3.3.18 Өгийнуур-Батцэнгэл-Ихтамир чиглэлийн 130.6 км хатуу хучилттай авто замыг барих /Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Ихтамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км /Архангай/<br><br>63 км авто замын барилгын ажлыг батлагдсан хөрөнгийн хэмжээнд хэрэгжүүлэх. | Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2019 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 9 дүгээр тушаалаар Архангай аймгийн Засаг даргын Тамгын газарт эрх шилжсэн.<br>2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулсан боловч шаардлага хангасан тендер ирүүлээгүй тул шууд гэрээний санал хүргүүлэхээр ажиллаж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2-4 улирал | |
| 4 | | 3.3.31 Сумын төвийн 8 дугаар багийг 1 дүгээр багтай холбох авто замын гүүрэн гарц /Дархан-Уул, Дархан сум/<br><br>Барилгын ажлыг эхлүүлсэн байна.<br><br>2-4 улирал | ТНБД-ын 2019 оны 39 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг 2019.03.06-ны өдөр зарласан бөгөөд 2019.04.08-ны өдөр нээсэн боловч тендер шалгаруулалтад нэг ч оролцогч ирээгүй.<br>Дархан-Уул аймгийн ЗДТГ-аас ирсэн хүсэлтийн дагуу уг төсөл, арга хэмжээг ЗТХСайдын 2019.05.01-ний өдрийн 130 дугаар тушаалаар орон нутгат эрх шилжүүлсэн.<br>Тендерийг зарлаж 2019.07.10-ны өдөр нээсэн боловч нэг ч оролцогч санал ирүүлээгүй.<br>Иймд 2019.07.31-ний өдөр Тендерийг дахин зарлаж, 2019.09.02-ны өдөр нээхэд нэг оролцогч санал ирүүлсэн.<br>Оролцогчийн ирүүлсэн санал төсөвт өртгөөс хэтэрсэн тул тендерийг хүчингүй болгосон. Гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулагдаагүй байгаа тул барилгын ажлыг дүгнэх боломжгүй. |
| 5 | | 3.3.40 Авто замдын гудамжнаас Монполимет комплекс орон сууц хүртэлх авто зам /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br>Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын захирамжаар Нийслэлийн ХААГ-т шилжүүлсэн.<br>2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн боловч одоогоор тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. |
| 6 | | 3.3.45 Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг, Булаг, Даваат, Наран, Рашаант, Цагаанчулуут баг/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4улирал | Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам /Орхон, Баян-Өндөрсум, Баянбулаг, Булаг, Даваат, Наран, Рашаант, Цагаанчулуутбаг/ ажилд Гүйцэтгэгчээр “Гарьд зам” ХХК шалгарсан 2019 оны 11 дүгээр сарын 04-нд гэрээ байгуулагдсан. |
| 7 | | 3.3.59 Баянбүрдийн тойрог орчмын авто зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 7-11 7,8,9,10,11 дүгээр хороо/<br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | ТӨБЗГ-т эрх шилжүүлсэн.<br>2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн боловч одоогоор тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. |
| 8 | | 3.3.62 Гэр хорооллын дундах хатуу хучилттай авто зам | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар |

| | | | |
|---|---|---|---|
| | | /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 1, 2, 22 дугаар хороо/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | эрх шилжсэн.<br>Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын 2019.02.19-ны өдрийн 110 дугаартай захирамжаар Сонгинохайрхан дүүргийн ХАА-д шилжүүлсэн.<br>Сонгинохайрхан дүүргийн ХАА-аас 2019.06.27-ны өдөр зарлаж, 2019.07.29-ны өдөр нээсэн боловч нэг ч оролцогч санал ирүүлээгүй.<br>Иймд тендерийг дахин 2019.07.31-ний өдөр зарлаж 2019.09.02-ны өдөр нээсэн боловч дахин нэг ч оролцогч санал ирүүлээгүй.<br>Иймд хуулийн дагуу шууд гэрээ байгуулахаар ажилласан боловч дахин нэг ч оролцогч санал ирүүлээгүй байна. |
| 9 | | 3.3.65 Дарь-Эхийн авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээ, 3.2 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | ТӨБЗГ-т эрх шилжүүлсэн.<br>2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн. Тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. |
| 10 | | 3.3.66 Дүүргийн доторх авто зам, явган хүний зам /Улаанбаатар, Баянгол дүүрэг/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | ТӨБЗГ-т эрх шилжүүлсэн.<br>2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн.<br>Тендерийг 2019.03.22-нд зарласан. 2019.04.22-нд нээсэн. Үнэлгээ хийгдэж байна. |
| 11 | | 3.3.77 Ривер Хиллс хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх авто зам, зогсоол, 1 км /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг 11 дүгээр хороо /<br>Барилгын ажлыг эхлүүлсэн байна.<br><br>2-4 улирал | ТӨБЗГ-т эрх шилжүүлсэн.<br>2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн.<br>Тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. |
| 12 | | 3.3.91 Тасганы овооноос хороодын нутаг дэвсгэрийн хилийн цэсийн дагуу Самбалхүндэвийн эргэмжийн газрын авто замтай нийлэх хатуу хучилттай авто зам, 2.6 км /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/<br><br>Барилгын ажлыг эхлүүлсэн байна.<br>2-4 улирал | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 8 дугаар тушаалаар Нийслэлд эрх шилжсэн.<br>2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн.<br>Тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | | 3.3.94 Фм 104.5 байраас гэр хорооллын дундуурх авто зам, 0.8 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br>Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын захирамжаар Нийслэлийн ХАА-ны газарт тендер шалгаруулалтыг зохион байгуулж, "Жинчин гранд" ХХК-д гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн. |
| 14 | | 3.3.98 Хороодын дундах хатуу хучилттай авто зам, 3.6 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 30, 31 дүгээр хороо/<br><br>Барилгын ажлыг эхлүүлсэн байна.<br><br>2-4 улирал | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br>Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын захирамжаар Сонгинохайрхан дүүрэгт худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.<br>2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн боловч одоогоор тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. |
| 15 | | 3.3.99 Хороодын дундах хатуу хучилттай авто зам, чулуун зам шинээр тавих /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг 4, 5, 14 дүгээр хороо/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | Нийслэлийн авто замын хөгжлийн газраас зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг гаргаж ирүүлснийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн.<br>2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн боловч одоогоор Үнэлгээний хороо байгуулагдсан. Тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. |
| 16 | | 3.3.100 Хороодын дундах чулуун зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12, 13 дугаар хороо/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br>Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын захирамжаар Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлэхээр шийдвэрлэсэн.<br>2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн боловч тендер шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээ хийгдэж байна. |
| 17 | | 3.3.102 Хорооны доторх авто зам, явган хүний зам засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг,<br>18, 19, 23, 27, 29 дүгээр хороо/ | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br>Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын захирамжаар Сонгинохайрхан дүүрэгт худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар шийдвэрлэсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | 2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн боловч одоогоор тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. |
| 18 | | 3.3.103 Хорооны хатуу хучилттай авто зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын захирамжаар Нийслэлийн Нийслэлийн Засаг даргын захирамжаар Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлэхээр шийдвэрлэсэн.<br>2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн боловч одоогоор тендерийг нээж үнэлгээ хийж байна. |
| 19 | | 3.3.104 Хувьсгалчдын гудамжнаас хорооны цогцолбор хүртэлх авто зам, 0.9 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br>Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын захирамжаар Сонгинохайрхан дүүрэгт худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар шийдвэрлэсэн.<br>2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн боловч одоогоор тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. |
| 20 | | 3.3.110 Хорооллын доторх авто замын засвар, 17 км /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7, 8, 9, 10 дугаар хороо/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | Худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д 2019.06.20-ны өдөр зарласан. 2019.07.22-ний өдөр нээсэн.<br>Тендерт шаардлага хангасан нэг ч материал ирүүлээгүй тул 2019.08.09-ний өдөр дахин зарласан. |
| 21 | | 3.3.116 Зам талбайн тохижилт, ногоон байгууламж, авто зам, авто замын засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 6, 15, 18,25, 26 дугаар хороо/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4улирал | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын 2019.03.18-ны өдрийн А/199 дугаартай захирамжаар Нийслэлийн ХАА-д шилжүүлсэн.<br>Нийслэлийн ХААГ-аас 2019.04.15-ны өдөр зарлаж, 2019.05.16-ны өдөр нээсэн. Тендерт 3 оролцогч оролцсон бөгөөд 2019.06.15-ны өдөр БЭЮС ХХК-д мэдэгдэл хүргүүлсэн. Гэвч 2019.06.11-ний өдөр Сангийн яаманд гомдол гарч тендерийг түр түдгэлзүүлсэн. Сангийн яамнаас дахин зарлах шийдвэр |

| | | | |
|---|---|---|---|
| | | | гарсан тул тендерийг 2019.07.25-ны өдөр дахин зарласан. Тендерт 2 оролцогч санал ирүүлсэн бөгөөд үнэлж, хамгийн сайн үнэлэгдсэн Рингроуд ХХК-д 2019.09.11-ний өдөр гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн. Оролцогч Жинчингранд ХХК-аас Сангийн яаманд 2019.09.19-эий өдөр гомдол гарсан тул тендерийг түр түдгэлзүүлсэн. Гүйцэтгэгч шалгараагүй. |
| 22 | | 3.3.119 Сумын төвөөс аймгийн төв хүртэлх авто замын засвар, 65 км /Ховд, Мөнххайрхан сум/<br><br>Барилгын ажлыг эхлүүлсэн байна.<br><br>2-4 улирал | Сайдын тушаалаар орон нутагт эрх шилжсэн. Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн.<br>2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн бөгөөд тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. |
| 23 | | 3.3.121 Хар хэмийн давааны засвар /Увс, Малчин сум/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br><br>Аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс ажлын зураг төсөл ирсэн даруй Үнэлгээний хороо байгуулж 2019.06.24-ны өдөр зарласан.<br>2019.07.01-ний өдөр нээсэн боловч нэг ч оролцогч санал ирүүлээгүй тул дахин зарласан боловч дахин нэг ч оролцогч оролцоогүй тул хуулийн дагуу тендерийг дахин зарласан бөгөөд тендерийг нээхэд 1 оролцогч оролцсон.<br>Үнэлж, "Гурвантэрмис" ХХК-тай гэрээ байгуулсан. |
| 24 | | 3.3.124 Хороодын доторх авто замын засвар, тохижилт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 6, 15, 18, 25 дугаар хороо/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4улирал | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын 2019.03.18-ны өдрийн А/199 дугаартай захирамжаар Нийслэлийн ХАА-д шилжүүлсэн.<br>Нийслэлийн ХААГ-аас 2019.04.15-ны өдөр зарлаж, 2019.05.16-ны өдөр нээсэн. Тендерт 3 оролцогч оролцсон бөгөөд 2019.06.15-ны өдөр БЭЮС ХХК-д мэдэгдэл хүргүүлсэн.<br>Гэвч 2019.06.11-ний өдөр Сангийн яаманд гомдол гарч тендерийг түр түдгэлзүүлсэн.<br>Сангийн яамнаас дахин зарлах шийдвэр гарсан тул тендерийг 2019.07.25-ны өдөр дахин зарласан. Тендерт 2 оролцогч санал ирүүлсэн бөгөөд үнэлж, хамгийн сайн үнэлэгдсэн Рингроуд ХХК-д 2019.09.11-ний өдөр гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн.<br>Оролцогч Жинчингранд ХХК-аас Сангийн яаманд 2019.09.19-эий өдөр гомдол гарсан тул тендерийг түр түдгэлзүүлсэн. Гүйцэтгэгч шалгараагүй. |

| | | | |
|---|---|---|---|
| 25 | | 3.3.125 Хорооллын доторх авто замын засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг 7, 8, 9, 10 дугаар хороо/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br>Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын захирамжаар НАЗХГ-д шилжүүлсэн. НАЗХГ-аас 2019.06.20-ны өдөр зарлаж, 2019.07.22-ны өдөр нээсэн.<br>52 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br>Тендер шалгаруулалтад 1 оролцогч оролцсон бөгөөд тендерийг үнэлэхэд шаардлагад нийцээгүй.<br>Иймд тендерийг дахин 2019.08.09-ны өдөр зарлаж, 2019.09.09-ний өдөр нээхэд нэг оролцогч санал ирүүлсэн бөгөөд тендерийг үнэлж байна. |
| 26 | | 3.3.126 Хорооллын доторх авто замын засвар, арчлалт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг 1, 2, 3, 7, 21, 27 дугаар хороо/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br>2-4улирал | Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн. Зураг төслийн ажлын даалгавар НАЗХГ-аас ирсэн даруй ТӨБЗГ-т хүргүүлнэ. Түүний дараа ТШ-ыг зохион байгуулна. |
| 27 | | 3.3.130 Хорооны авто зам, явган хүний замын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг,<br>11, 17, 18, 19 дүгээр хороо/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br>Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын 2019.03.22-ны өдрийн А/222 дугаартай захирамжаар Баянгол дүүргийн ХАА-д шилжүүлсэн.<br>Тендер шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна. |
| 28 | | 3.3.153 Далан, гүүрийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо, Булгийн 10, 11 дүгээр гудамж/<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>2-4 улирал | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br>Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын 2019.04.04-ний өдрийн А/264 дугаартай захирамжаар Чингэлтэй дүүргийн ХАА-д шилжүүлсэн.<br>Чингэлтэй дүүргийн ХАА-аас 2019.05.10-ны өдөр зарлаж, 2019.06.10-ны өдөр нээсэн боловч нэг оролцогч санал ирүүлээгүй.<br>Тендерийг дахин 2019.06.11-ний өдөр зарлаж, 2019.07.16-ны өдөр нээхэд дахин нэг ч оролцогч санал ирүүлээгүй болно.<br>Хуулийн дагуу шууд гэрээ байгуулахаар 5 байгууллагад урилга хүргүүлсэн боловч нэг ч оролцогчоос санал ирээгүй байна. |

| | | | |
|---|---|---|---|
| 29 | | 3.3.2 АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам төсөл”-ийн Багц-4: Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто зам.<br><br>Барилгын ажил бүрэн хийгдэж дууссан байна.<br><br>1-4 улирал | Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад 2016 онд гарсан шүүхийн шийдвэрийн улмаас АХБ-наас хөрөнгө оруулалт хийх боломжгүй мэдэгдлийг ирүүлсэн.<br>АХБ-аас шүүхийн шийдвэр хүчингүй болсон тохиолдолд тус багц хэсгийн зам барилгын ажилд АХБ-аас хөрөнгө оруулалт олгох боломжтой гэсэн албан бичгийг АХБ-аас 2019 оны 02 дугаар сард ирүүлсэн.<br>Шүүхийн шийдвэр хэрэгжсэн талаарх тодорхойлолт хүссэн албан бичгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдөр хүргүүлсэн.<br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас шүүхийн шийдвэр хангагдсан талаар хариу ирүүлснийг үндэслэн АХБ-нд тус багц хэсгийн зам барилгын ажлыг санхүүжүүлэх хүсэлтийг 2019 оны 03 сарын 28-ны өдрийн 03/40 албан тоотоор хүргүүлсэн.<br>АХБ-аас зээл хянах ажлын хэсэг 2019 оны 06 сарын 17-27-ны өдрүүдэд Монгол Улсад ирж ажилласан батус ажлын хэсэгт дээрх албан бичигт албан ёсны хариу өгөх хүсэлтийг тавьсан. Ажлын хэсгийн хүрээнд Сангийн яам, АХБ, Зам тээврийн хөгжлийн яам хооронд байгуулсан санамж бичигт АХБ-аас 7 сард багтаан албан ёсны хариуг ирүүлэхээр тусгасан ба АХБ-аас дахин тендер зарлах зөвшөөрлийг 209.07.30-ний өдөр олгосон.<br>Тус ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгээр томилогдон ажилласан. АХБ-аас ирүүлсэн зөвшөөрлийн дагуу тендерийн баримт бичгийн төслийг боловсруулж, АХБ-нд хүргүүлэн 2019.09.11-ний өдөр зөвшөөрөл авсан. Т<br>ендерийг 2019.09.12-ны өдөр зарласан ба 2019.10.25-ны өдөр нээж, үнэлгээний ажлыг хэрэгжүүлэх тайланг АХБ-нд 2019 оны 11 сарын 27-ны өдөр хүргүүлсэн.<br>АХБ-аас үнэлгээний тайланд 2019 оны 12 сарын 13-ны өдөр холбогдох саналыг ирүүлсэн ба ирүүлсэн саналын дагуу ажиллаж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| 30 | | 3.3.70 Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км /Архангай/<br><br>Барилгын ажлыг эхлүүлсэн байна.<br><br>2-4 улирал | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br>Үнэлгээний хороо 2019.04.15-ны өдөр байгуулагдсан, Тендерийн баримт бичгийг боловсруулж байгаа бөгөөд ТШ-ыг зарласан бөгөөд 2019.06.28-ны өдөр нээсэн боловч тендерт нэг ч оролцогч оролцоогүй болно. Иймд ТШ-г дахин зарласан.<br>ТШ-ыг нээхэд "НОРБРУ" ХХК ганцаараа оролцсон боловч шаардлагад нийцээгүй тул тендерийг бүхэлд нь хүчингүй болгосон.<br>Иймд хуулийн дагуу 5 оролцогчид шууд гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд “Хурдны зам” ХХК-ийн ирүүлсэн санал хамгийн сайн үнэлэгдэж гэрээ байгуулах мэдэгдлийг 2019.08.23-ны өдөр хүргүүлсэн.<br>Гэвч АТГ-т гомдол гарсан бөгөөд АТГ-аас ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулсны дараа шууд гэрээ байгуулахыг зөвлөсөн.<br>2019.11.11-нд “хурдны зам” ХХК-тай гэрээ байгуулсан. |

### 2.2. МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилт:

| Нийт арга хэмжээ | Үүнээс хэрэгжилтийн хувиар | | | | | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | 100% | 70% | 40% | 0% | Үнэлэх боломжгүй | |
| 24 | 24 | - | - | - | - | **100** |

МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын хүрээнд дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх зорилтоор “Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 1600 км-ээр нэмэгдүүлэх”-ээр төлөвлөсөн бөгөөд 2019 оны 4 дүгээр улирлын байдлаар 2465,22 км авто замыг барьж гүйцэтгэсэн нь анх төлөвлөснөөс 54 хувиар буюу 865,22 км-ээр илүү гүйцэтгэсэн байна.

Хэрэгжилтийг шалгахад 100%-ийн биелэлттэй 24 арга хэмжээ байна. Хэрэгжилт 100 хувьтай байна.

### 2.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

| Нийт арга хэмжээ | Үүнээс хэрэгжилтийн хувиар | | | | | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | 100% | 70% | 40% | 0% | Үнэлэх боломжгүй | |
| 73 | 24 | 6 | 4 | - | 39 | **87,6** |

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар авч үзэхэд 100%-ийн биелэлттэй 24, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн хэрэгжилттэй 6, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй 4, үнэлэх боломжгүй 39 арга хэмжээ байна. Хэрэгжилт 87,6 хувьтай байна.

**Үүнээс 2019 оны жилийн эцсийн байдлаар эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн 4 арга хэмжээ нь:**

| № | Арга хэмжээний нэр | Биелэлт |
|---|---|---|
| **Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ** | | |
| 1 | 2. Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай авто замыг барих | Концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр ЗГ-ын 2017.06.14-ний өдрийн 166 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмж тусгасан. Уг тогтоолын дагуу ҮХГ-аас 2017.08.16-ны өдөр “Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км цемент бетон хучилттай их даацын авто зам төсөл”-ийн концесс олгох 2 үе шаттай уралдаант шалгаруулалтыг зарласан. Урьдчилсан шалгаруулалтад оролцох саналыг 2017.10.16-ны өдрийн 11.00 цаг хүртэл хүлээн авсан бөгөөд тус төсөлд 1 оролцогч санал ирүүлсэн бөгөөд комисс уг оролцогчийн саналыг үнэлж, дараагийн үе шат болох уралдаант шалгаруулалтад оруулахаар шийдвэрлэсэн.<br>Комиссоос уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулан тус оролцогчид 2018.01.16-ны өдөр баримт бичгийг олгож эхэлсэн бөгөөд төслийн саналыг 2018.04.19-ний өдрийн 11.00 цагт нээсэн боловч нэг ч санал ирээгүй байна. Концессын хуулийн дагуу концесс эзэмшигчийг шалгаруулж гэрээ байгуулан хэрэгилтэд хяналт тавих эрх үүргийг Үндэсний хөгжлийн газар хэрэгжүүлэн ажилладаг.<br>Авто зам барих хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар буюу концессын “Барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Үндэсний хөгжлийн газраас концессын хуулийн дагуу шууд гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. |
| 2 | 3. Өгийнуур-Батцэнгэл-Их Тамир чиглэлийн 130.6 км хатуу хучилттай авто замыг барих | **АЗБХЗГ:** Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд тухайн төслийн эхний 63 км замыг 2019-2020 онд хэрэгжүүлэхээр XIII.1.1.48 дугаартайгаар тусгагдсан.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019.01.10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар Архангай аймгийн Засаг дарга зохион байгуулахаар эрх шилжсэн.<br>Тендерийг зарлаж, 2019.06.14-ний өдөр нээсэн боловч шаардлагад нийцсэн нэг ч оролцогч ирээгүй. Тендерийг дахин зарлаж 2019.08.02-нд нээсэн бөгөөд нэг ч компани оролцоогүй тул "Хурдны зам" ХХК-тай 2019.11.11-ний өдөр 57090.92 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шууд гэрээ байгуулсан.<br>Гүйцэтгэгч болон орон нутгийн зүгээс төсөвт магадлал хийлгэхээр холбогдох газарт хүсэлт гаргаад байна. |
| 3 | 6. Дашинчилэн-Их тамир чиглэлийн 130 км авто замын Орхон голын 220 урт метр төмөр бетон гүүрийг барих | **АЗБХЗГ:** Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд тухайн төслийн эхний 63 км замыг 2019-2020 онд хэрэгжүүлэхээр XIII.1.1.48 дугаартайгаар тусгагдсан.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх Архангай аймагт шилжсэн.<br>Тендерийг зарлаж, 2019.06.14-ний өдөр нээсэн боловч шаардлагад нийцсэн нэг ч оролцогч ирээгүй.<br>Тендерийг дахин зарлаж 2019.08.02-нд нээсэн бөгөөд компани оролцоогүй тул "Хурдны зам" ХХК-тай 2019.11.11-ны өдөр 57090.92 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шууд гэрээ байгуулсан.<br>Гүйцэтгэгч болон орон нутгийн зүгээс төсөвт магадлал хийлгэхээр холбогдох газарт хүсэлт гаргаад байна. |
| 4 | Дархан-Улаанбаатарын чиглэлийн авто замаас Мандал сумын төв хүртэлх 32 км хатуу хучилттай авто зам барих | **АЗБХЗГ:** Зураг төсөл хийгдсэн. Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна.<br>Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2017.08.15-ны өдрийн 01/3569 тоот албан бичгээр Сангийн яаманд санал хүргүүлсэн. **2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй** учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br>Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн. |

| | | |
|---|---|---|
| | | Тендерийг 2019.03.22-ний өдөр зарласан бөгөөд 2019.04.22-ны өдөр нээсэн.<br>Тендер шалгаруулалтад 3 оролцогч оролцсон бөгөөд гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн боловч Сангийн яаманд гомдол гарсан тул түр түдгэлзүүлсэн.<br>Сангийн яамнаас 2019.05.22-ны өдөр захиалагчийн шийдвэр үндэслэлтэй албан бичиг ирсэн. Иймд гүйцэтгэгч “Замын битум” ХХК-тай 2019.06.03-ны өдөр гэрээ байгуулсан. Барилгын ажил эхэлсэн.<br>Талбайд дээр 110 ажилтан, 60 машин механизм ажил гүйцэтгэж байна.<br>Асфальтны үйлдвэр шинээр барьсан.<br>Далангийн ажил-75%-тай.32 км-т 50 ширхэг хоолой тавих ажил 80%-тай явж байна. Битум татаж дууссан. Суурийн ажил хийгдэж байна. Нийт барилга угсралтын ажлын явц 35%-тай байна. |

**2.4. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт.**

| Нийт арга хэмжээ | Үүнээс хэрэгжилтийн хувиар | | | | | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|
| | 100% | 70% | 40% | 0% | Үнэлэх боломжгүй | |
| 21 | 17 | 3 | - | - | 1 | **95,5** |

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар авч үзэхэд 100%-ийн биелэлттэй 17, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн хэрэгжилттэй 3, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилт 95,5 хувьтай байна.

**Үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ нь:**

| № | Арга хэмжээний нэр | Биелэлт |
|---|---|---|
| 1 | 7.1.7 Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам | **АЗБХЗГ:** “Шинжиан шин-фа” ХХК барилгын ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулсан.<br>Зам барилгын ажлыг эхлүүлэх 06/18/2017 дугаартай зөвшөөрлийг 2017.12.26-ны өдөр олгосон.<br>Үндэсний хөгжлийн газраас өгсөн тайлбараар концессын гэрээний дагуу Зөвлөхийн зардлыг холбогдох дансанд байршуулаагүй тул Зөвлөх барилгын ажлын талбайд гараагүй байна.<br>Концесс эзэмшигчээс далан, ухмал, хиймэл байгууламжийн ажил гүйцэтгэж байгаа бөгөөд ойролцоогоор нийт ажлын **20%-ийг хийж гүйцэтгэсэн** талаар Үндэсний хөгжлийн газарт мэдээ өгсөн боловч эдгээр ажил нь Зөвлөхөөр баталгаажаагүй байна. Эрх бүхий байгууллагаас шалгалт хийж байгаа бөгөөд 2019 онд зам барилгын ажил хийгдээгүй тогтоосон ба зам барилгын ажлыг эхлүүлэх талаар тодорхой тов гараагүй. |

**2.5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт:**

| № | Эрх зүйн актын нэр | Нийт арга хэмжээ /заалт/ | Үүнээс хэрэгжилтийн хувиар | | | | | | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100% | 70% | 30% | 0% | Хугацаа болоо гүй | Хүчин гүй болсон | |
| 1 | Хууль | 11 | 8 | 2 | - | - | 1 | - | 94,0 |
| 2 | УИХ-ын тогтоол | 1 | - | 1 | - | - | - | - | 70,0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 1 | - | 1 | - | - | - | - | 70,0 |
| 4 | Засгийн газрын тогтоол | 37 | 20 | 10 | - | - | 7 | - | 90.0 |
| 5 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 28 | 17 | 7 | 1 | - | 3 | - | 88.8 |
| | **Нийт** | **78** | **45** | **21** | **1** | **-** | **11** | **-** | **89.6** |

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар 100%-ийн биелэлттэй 45, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн хэрэгжилттэй 21, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн хэрэгжилттэй 1, хугацаа болоогүй 11 арга хэмжээ байна. Хэрэгжилт 89,6 хувьтай байна.

**Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ нь:**

| № | Зорилтот түвшин | Арга хэмжээний нэр | Биелэлт |
|---|---|---|---|
| **Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ нь:** | | | |
| 1 | "Өмнөговь аймгийн Засаг даргын мэдээлэлтэй холбогдуулан холбогдох арга хэмжээ авч ажиллах тухай" 2011.05.25-ны өдрийн №26 | 1.4 Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд тусгагдсан Мандалговь-Даланзадгад чиглэлийн 163 км, Даланзадгад-Оюутолгой чиглэлийн 251 км хатуу хучилттай авто замын ажлын явцыг түргэтгэх, "Гурвансайхан" онгоцны буудлыг өргөтгөх асуудлыг судалж шийдвэрлэх | Мандалговь-Даланзадгад чиглэлийн 163 км авто замын ажлыг дуусгаж, 2014 онд Өмнөговь аймгийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбосон.<br>2. Даланзадгад-Оюутолгой чиглэлийн 251 км хатуу хучилттай замыг 2011 онд эргэн төлөгдөх нөхцөлөөр барих тендер зарласан боловч сонирхогч компани байхгүй шалтгаанаар амжилтгүй болсон. Цогт-Овоо-Даланзадгад чиглэлийн хатуу хучилттай авто замыг 2014 онд ашиглалтад оруулсан бөгөөд Цогтцэций сумыг энэхүү чиглэлийн авто замд холбох нь тус сумыг Даланзадгад болон Улаанбаатар чиглэлд холбох зорилтыг зэрэг хангах тул эхний ээлжинд барих нь зүйтэй гэсэн чиглэлийн баримталж байна. Улмаар Даланзадгад-Цогт-Овоо чиглэлийн авто замын "Шартээгийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам"-ын төслийг Засгийн газрын 2015 оны 85 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулж, концесс эзэмшигчийг шалгаруулан концессын "барих-шилжүүлэх" гэрээ байгуулсан. Зөвлөхийн сонгон шалгаруулалттай холбоотой шүүхийн маргаан дуусгавар болсон тул концессын гэрээг 2019.10.30 хүртэл сунгасан бөгөөд Зөвлөхийн гэрээг 2019.04.13-ны өдөр байгуулснаар зам барилгын ажлыг эхлүүлэх нөхцөл бүрдсэн. Тус яамнаас 2019.05.27-ны өдөр 06/22/2019 дугаартай замын барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон. Одоогоор замын чиг сэргээх, ухмал, далангийн ажил хийгдэж байна. Ажлын явц 4.7%. Харин Цогтцэций-Оюутолгой чиглэлийн авто замын зураг төсөл хийгдсэн боловч санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй тул 2020 он өнгөртөл хэрэгжүүлэх боломжгүй юм. |

**2.6. Зам, тээврийн хөгжлийн Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт:**

| Нийт заалт | Үүнээс хэрэгжилтийн хувиар | | | | | Хүчингүй болсон | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 100% | 70% | 30% | 0% | Хугацаа болоогүй | | |
| 74 | 43 | 13 | 9 | 1 | 5 | 3 | **83.0** |

Зам тээврийн хөгжлийн Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар авч үзэхэд 100%-ийн биелэлттэй 43, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн хэрэгжилттэй 13, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн хэрэгжилттэй 9, тасарсан 1, хугацаа болоогүй 5, хүчингүй болсон 3 арга хэмжээ байна. Хэрэгжилт 83,0 хувьтай байна.

**Тасарсан 1, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн хэрэгжилттэй 9 арга хэмжээ нь:**

| № | Зорилтот түвшин | Арга хэмжээний нэр | Биелэлт |
|---|---|---|---|
| **Тасарсан 1 арга хэмжээ нь:** | | | |
| 1 | Мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах тухай 2019.09.07-ны өдрийн №286 | 2. Тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд/-д, түр замын байнгын бэлэн байдлыг хангах ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/-т тус тус даалгасугай. | Түр замын санхүүжилтийн эх үүсвэрийг зам барилгын ажлын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэхээр холбогдох материалыг бэлтгэж байна. |
| **Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ нь:** | | | |
| 1 | Авто замын чиглэл батлах тухай 2015.01.16-ны өдрийн №16 | .Батлагдсан чиглэлийн дагуу авто замыг барих, ашиглах талаар гэрээ байгуулах, батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг АЗТБХЗГ /Ц.Цогтбаатар/-т үүрэг болгосугай.<br>/Улаан-Овоогийн нүүрсний уурхайгаас Зэлтэрийн боомт хүртэл 18.5км/ | Тушаалыг хүсэлт гаргасан уурхай эзэмшигч компанид хүргүүлсэн. Батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж авсан. Санхүүгийн хүндрэлтэй асуудлаас шалтгаалан авто замын барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй байгаа талаар тус компаниас мэдэгдсэн. Зам барилгын ажил эхлүүлээгүй. Тухайн чиглэлийг батлахад олон төрлийн судалгаа, зөвшөөрөл авдаг учир нэгэнт батлагдсан чиглэлийг хадгалах нь зүйтэй юм. |
| 2 | Авто замын чиглэл батлах тухай 2015.04.16-ны өдрийн №104 | 2.Батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг АЗТБХЗГ-ын дарга /Д.Доржханд/-д үүрэг болгосугай.<br>/Цагаанхадаас Гашуунсухайт боомт хүртэлх 18.6 км авто замын чиглэл/ | Батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж авсан. Тус чиглэлийн замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил хийигдсэн. "Оюу Толгой" ХХК-аас авто зам барих гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлсэн бөгөөд уг асуудлыг судалж, зам барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон.<br>2016 оны зам барилгын ажил 04 сарын 18-ны өдөр эхэлсэн.<br>2016 онд далан – 99.4%, ухмал – |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 100%, хиймэл байгууламж 100%, хайрган дэд суурь 97.7%, цементээр бэхжүүлсэн суурь 22%, битум цацлага – 14.4%, асфальт макадам – 11.6%, хөвөө 11.6%, цементбетон хучилт 25% хийгдсэн.<br>Гүйцэтгэгч "Очир зам" ХХК зам барилгын ажлыг 2016 онд дуусгах гэрээ байгуулсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүй тул гэрээ цуцлагдсан.<br>Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ 2017.11.12-ны өдөр "Оюутолгой" ХХК-ийн үйл ажиллагаатай танилцах үеэр Гүйцэтгэх захирал Армандо Торрес уг замыг ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт хийгдэж байгаа бөгөөд 2018 онд багтаан ашиглалтанд оруулахаар төлөвлөж байгаа талаар тайлбар хийсэн.<br>Оюутолгойн Хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгээс Цагаанхад-Оюутолгой чиглэлийн авто замыг хэрхэх талаар тодруулахад 2019 оны хөрөнгө оруулалтын төлвөллөгөөндөө тусгахаар төлөвлөж байгаа талаар мэдээлэл өгсөн.<br>Энэ талаар ажлын хэсгийн тайлан, дүгнэлтэд 2019 онд багтаан зам барилгын ажлыг дуусгах шаардлагатай талаар тусгасан.<br>Гэвч "Оюутолгой" ХХК нь тус замын барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөндөө тусгаагүй байна.<br>Хэрэв тус чиглэлийн авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэх талаар арга хэмжээ авахгүй бол тээвэрлэлтийн чиглэл тогтоосон сайдын тушаалаа хүчингүй болгохыг мэдэгдсэн албан бичгийг 2019.09.16-ны өдөр "Оюутолгой" ХХК-д хүргүүлсэн. |
| 3 | Авто замын чиглэл батлах тухай 2015.10.13-ны өдрийн №267 | 2.Батлагдсан чиглэлийн дагуу авто замыг барих, ашиглах талаар гэрээ байгуулах, батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг АЗТБХЗГ /Д.Доржханд/-т үүрэг болгосугай. /Цахиурт-Овоогийн төмрийн хүдрийн уурхайгаас Баруун-Урт-Бичигтийн боомт чиглэлийн авто замтай холбогдох 46.6 км авто зам/ | Чиглэл батлагдсан тушаалыг уурхай эзэмшигчид хүргүүлсэн. Батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж авсан. Одоогоор тус компаниас авто зам барих талаар гэрээ байгуулах хүсэлт ирүүлээгүй бөгөөд зам барилгын ажил эхлээгүй. Төмрийн хүдрийн ханш зах зээл дээр унаснаас хатуу хучилттай авто зам барих санхүүжилт босгох боломжгүй болсон гэсэн тайлбар өгдөг. Зам, тээврийн хяналтын байцаагч нар хэд хэдэн удаа газар дээр нь очиж тээвэрлэлтийн байдалтай танилцан, авто зам барих шаардлага тавьсан, мөн орон нутгаас авто замын |

| | | | |
|---|---|---|---|
| | | | асуудлаа шийдвэрлэсний дараа тээвэрлэлт гүйцэтгэх шаардлага тавьсан. Одоогоор тус компани нь төмрийн хүдрийн тээвэрлэлтээ зогсоогоод байгаа бөгөөд хүдэр боловсруулах үйлдвэр барьж байгаа талаар мэдээлэл өгсөн. |
| 4 | Авто замын чиглэл батлах тухай 2015.11.25-ны өдрийн №316<br><br>/2015.12.18-ны №355 тушаалаар 3 дахь заалтыг хүчингүйд тооцсон/ | Замын трассын дайран өнгөрөх цэгүүдийг зураг төсөл боловсруулах шатанд нарийвчлан тогтоолгож, батлагдсан чиглэлийн дагуу авто замыг барих, ашиглах, шилжүүлэх гэрээ байгуулах, батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг АЗБХЗГ /Д.Доржханд/-т үүрэг болгосугай. /Хөөтийн нүүрсний уурхайгаас Бичигт боомт хүртэлх авто замын чиглэл/ | Чиглэл баталсан тушаалыг "Буман-Олз" ХХК-д хүргүүлсэн. Батлагдсан чиглэлийг мэдээллийн санд бүртгэж авсан.<br>Тус компаниас замын зураг төслийг мэргэжлийн компаниар гүйцэтгүүлсэн ба зам барилгын ажлыг гүйцэтгэгч компанийг сонгосон тул ажил эхлүүлэх зөвшөөрөл олгохыг хүссэн албан бичиг ирүүлсний дагуу Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон.<br>2017 онд 20 км-т хөрс хуулалт, 10 км-т далангийн 1-р үеийн дүүргэлт хийгээд санхүүжилтээс шалтгаалан барилгын ажил зогссон.<br>Гүйцэтгэгч компани нь цаашид зам барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тул гэрээгээ цуцалсан байна. "Буман-Олз" ХХК нь Хятадын талаас эрчим хүчний нүүрсний импортод хязгаарлалт тавьж байгаа тул санхүүжилт босгоход хүндрэл үүссэн гэсэн тайлбар өгсөн. Мөн тээвэрлэлтээ зогсоосон. |
| 5 | Авто замын ашиглалтын байдалд хяналт тавих, төлбөр авах үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2016.04.21 №100 | Авто зам, замын байгууламжаар зайлшгүй тохиолдолд даац хэтэрсэн, зөвшөөрөгдсөнөөс илүү овор хэмжээтэй тээврийн хэрэгслээр зорчих тохиолдолд зөвшөөрөл олгох зохицуулалтыг шинэчлэх талаар зохих дүрэм, журам, стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэхийг АЗТБХЗГ /Д.Доржханд/ | Хяналт, шалгалтыг эрчимжүүлэх зорилгоор 2018 онд тээврийн хэрэгслийн жин, тонн хэмжих төхөөрөмж худалдан авч, материаллаг баазыг бэхжүүлсэн. АВТО ТЭЭВЭР БИЕЛЭЛТ БИЧНЭ. |
| 6 | Техникийн баримт бичиг батлах тухай 2018.05.02 №87 | Батлагдсан техникийн баримт бичгийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг АЗБХЗГ /Д.Доржханд/, ХШҮДАГ /Т.Гомбосүрэн/-т тус тус даалгасугай. /"Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ тооцох аргачлал" техникийн баримт бичиг | Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ тооцох аргачлал" техникийн баримт бичигт хяналт тавьж ажиллаж байна.<br>ЭНЭ БАРИМТ БИЧГИЙГ БАТАЛСАН ТУШААЛ УЛСЫН НЭГДСЭН САНД БҮРТГЭГДЭЭГҮЙ БАЙГАА ТУЛ ХЭРЭГЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА. ЭНХТУЯА -ГЭРЭЛНЯМААС ТОДРУУЛНА УУ. |
| 7 | Ажлын хэсэг байгуулах тухай 2018.10.01 №219/А/373 | Аялал жуулчлалын гол чиглэл дагуу дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж батлуулах ажлыг 2018.10.20-ны дотор хийж | Ажлын хэсэг Аялал жуулчлалын гол чиглэл дагуу аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. БТГ БИЕЛЭЛТ |

| | | | |
|---|---|---|---|
| | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай хамтарсан тушаал | гүйцэтгэхийг Ажлын хэсэг /Ц.Батбаяр/-т даалгасугай. /Аялал жуулчлалын гол чиглэл дагуу аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг/ | БИЧНЭ. Загдраднаа |
| 8 | Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын талаар авах зарим арга хэмжээний тухай 2019.04.23-ны өдрийн №125 | Авто зам дайран өнгөрч байгаа суурьшлын бүс болон Төв аймгийн Баянчандмань сум, Сэлэнгэ аймгийн Баянгол сум, Дархан-Уул аймгийн Хонгор сумын төвд явган зорчигчийн гүүрэн гарц төлөвлөх, уг ажлыг “Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк”-ны санхүүжилтээр баригдах авто замын зураг төсөлд тусгуулах ажлыг зохион байгуулахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/, “Зам, тээврийн хөгжлийн төв”ТӨҮГ /Р.Буд/ нарт; | “Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк”-ны санхүүжилтээр баригдах авто замын зураг төсөлд Төв аймгийн Баянчандмань сум, Сэлэнгэ аймгийн Баянгол сум, Дархан-Уул аймгийн Хонгор сумын төвд явган зорчигчийн гүүрэн гарц барих ажлыг нэмж оруулах санал тавьсан боловч хүсэлтийг хүлээн аваагүй. |
| 9 | Тушаалд өөрчлөлт оруулах тухай 2019.07.18-ны өдрийн №239 | 1. ЗТХС-ын 2019.02.09-ний өдрийн “Бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай” 40 дүгээр тушаалын “Нэг:<br>2. Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдод “Улаанбаатар-Дархан” чиглэлийн авто замыг барьж ашиглалтанд оруулах ажлыг” гэснийг “Нэг:2 Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Доржхандад “Улаанбаатар-Дархан” чиглэлийн авто замыг барьж ашиглалтанд оруулах ажлыг” гэж өөрчилсүгэй.<br><br>2. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгүүлэхэд анхаарч, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч, хяналт тавьж ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Д.Доржханд/-д үүрэг болгосугай. | Зам барилгын ажлынг батлагдсан график төлөвлөгөө болон Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг зам барилгын ажлын талбай дээр газар дээр нь хяналт тавьж, холбогдох зөвлөмж чиглэл, ажлын уялдаа холбоогоор хангаж ажиллаж байна. Барилгын ажил 30%-тай хийгдэж байна. |

## 2.7. Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлт:

| Нийт заалт | Үүнээс хэрэгжилтийн хувиар | | | | | | Биелэлт / хувиар / |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 100% | 70% | 30% | 0% | тасарсан | Хугацаа болоогүй | |
| 51 | 42 | 7 | - | - | - | 2 | **95,7** |

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар авч үзэхэд 100%-ийн биелэлттэй 42, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ байна. Хэрэгжилт 95,7 хувьтай байна.

**2.8. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт:**

| Нийт заалт | Үүнээс хэрэгжилтийн хувиар | | | | | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | 100% | 70% | 30% | 0% | Үнэлэх боломжгүй | |
| 2 | 1 | - | - | - | 1 | **100** |

Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд тус газраас 2 асуудал хэлэлцүүлэхээр тусгаснаас 100 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилт 100 хувьтай байна.

**2.9. Сайдын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөний биелэлт:**

| Арга хэмжээ ний тоо | Үүнээс хэрэгжилтийн хувиар | | | | | | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 100% | 70% | 30% | Хойшлогд сон | Нэмж оруулсан | Хугацаа болоогүй | |
| 4 | 3 | 1 | - | - | - | - | **92,5** |

Сайдын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөнд 4 арга хэмжээ хяналтад байгаагаас 100%-ийн биелэлттэй 3, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилт 92,5 хувьтай байна.

**2.10. Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлт:**

Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлтийг өссөн дүнгээр нь авч үзвэл:

| Арга хэмжээ ний тоо | Үүнээс хэрэгжилтийн хувиар | | | | | | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 100% | 70% | 30% | Үнэлэх боломжгүй | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон | |
| **8** | **4** | **4** | **-** | **-** | **-** | **-** | **85,0** |

Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрээс 8 арга хэмжээ хяналтад байгаагаас 100%-ийн биелэлттэй 4, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ байна. Хэрэгжилт 85,0 хувьтай.

**2.11. Зам, тээврийн хөгжлийн Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:**

Зам, тээврийн хөгжлийн Сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд авто замын чиглэлээр 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 100%-ийн биелэлттэй 3, 70%-ийн биелэлттэй 4, тасарсан 7 арга хэмжээ байна.

Хэрэгжилт **41,4** хувьтай байна.

| № | Хариуцах байгууллага, газар, хэлтэс | Төлөвлөсөн нийт арга хэмжээ | | | | Үнэлгээ, хувиар | | | | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт | Толгойлон хэрэгжүүлэх | Хамтарч хэрэгжүүлэх | Хувь | 100 | 70 | 30 | 0 | Хугацаа болоогүй | |
| 1 | АЗБХЗГ | 14 | 12 | 2 | **48,3** | 3 | 4 | - | 7 | - | **41,4** |

Толгойлон хэрэгжүүлэх 12 арга хэмжээний хэрэгжилт **48,3** %-тай байна.

**Тасарсан 7 арга хэмжээнүүд нь:**

| № | Арга хэмжээний нэр | Биелэлт |
|---|---|---|
| | **Тасарсан 7 арга хэмжээ :** | |
| 1 | Улаанбаатар хотын урдаас хойш чиглэлд 25.3 км Сэлбэ хурдны авто замын барилгын ажлыг эхлүүлэх | МУ-ын ЗГ-ын 2016 оны 196 дугаар тогтоолоор Сангийн яамны дэргэдэх “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн нэгж нь тус төслийг хэрэгжүүлэн ажиллахаар тусгагдсан. Хөрөнгийн асуудал шийдэгдээгүй. |
| 2 | Улаанбаатар хотын зүүнээс баруун чиглэлд 36 км Туул хурдны авто замын барилгын ажлыг эхлүүлэх | МУ-ын ЗГ-ын 2016 оны 196 дугаар тогтоолоор Сангийн яамны дэргэдэх “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн нэгж нь тус төслийг хэрэгжүүлэн ажиллахаар тусгагдсан. Хөрөнгийн асуудал шийдэгдээгүй. |
| 3 | Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 13 дугаар хороо, Туул гол дээгүүрх төмөрбетон гүүрийн их засварын ажлыг эхлүүлэх | ХУД-ийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай *Шувуу фабрик- Сонгино чиглэлийн замын Туул гол дээрх 256 у/м* төмөрбетон гүүрэнд эвдрэл гарсны улмаас авто тээврийн хөдөлгөөнд аюултай нөхцөл байдал үүсэж, тээврийн хэрэгсэл зорчих боломжгүй болсон тул мэргэжлийн хяналтын газраас 2017 оны 10 дугаар сарын 02-нд үзлэг шалгалт хийж 2017 оны 10 дугаар сарын 04-ны 02-07-107/1042 дугаартай дүгнэлт гарч, НЗД-ын 2017 оны А/861 дүгээр захирамжаар тус гүүрийн зураг төслийг боловсруулах тухай захирамж гарсны дагуу холбогдох арга хэмжээг авч, гүүрийн ТАТ тогтоож их засварын ажлын зураг төслийг боловсруулан магадлалаар батлуулан НАЗГ хүлээн авсан. 2019 онд гүүрийн барилгын ажлын хөрөнгө шийдвэрлэгдээгүй болно. |
| 4 | Улаанбаатар хотын орох, гарах хяналтын цэгүүдэд сүүлийн үеийн дэвшилтэт технологид суурилсан хяналтын жин бүхий цахим хяналт, бүртгэлийг нэвтрүүлэх замаар ачааны автомашинуудыг даацаар нь ангилан холбогдох стандартуудыг мөрдүүлэх; | Биелэлт ирүүлээгүй. |
| 5 | Нарантуул ОУХТөвийн баруун | Нарантуул ОУХТөвийн баруун уулзвар болон |

| | | |
|---|---|---|
| | уулзвар болон төмөр зам дээгүүр гүүрэн гарцыг шинээр барих ажлыг эхлүүлэх. | төмөр зам дээгүүрх гүүрэн гарцын зураг төслийг 2008 онд БНХАУ-ын BMEPDI ХХК гүйцэтгэсэн. Барилгын ажлын хөрөнгө шийдвэрлэгдээгүй болно. |
| 6 | 3.7 Сонсголонгийн уулзвар, төмөр зам дээгүүрх гүүрэн гарцын зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг эхлүүлэх. | Техник эдийн засгийн үндэслэлийг 2012 онд Gauff Ingenieure гүйцэтгэсэн. Нарийвчилсан зураг төсөл болон барилгын ажлын хөрөнгө шийдвэрлэгдээгүй болно. |
| 7 | 3.9 Төмөр замаар тусгаарлагдсан гудамж, авто замуудыг холбосон нүхэн гарцуудыг шинээр төлөвлөх, зураг төсөл боловсруулах, барих ажлыг эхлүүлэх /Нийт 7 нүхэн гарц барих/ | Биелэлт ирүүлээгүй. |

**2.12. Ил тод нээлттэй байдлын үнэлгээний биелэлт**

| Нийт заалт | Үүнээс хэрэгжилтийн хувиар | | | | | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | 100% | 70% | 30% | 0% | Хугацаа болоогүй | |
| 7 | 6 | 1 | - | - | - | **95,7** |

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, хүнд сурталгүй, авлигаас ангид байлгах, иргэдэд үйлчлэх үйлчилгээг ил тод хөнгөн шуурхай болгох хангах талаар тус газраас хийж буй ажлын явцыг шалгахад ба 100%-ийн биелэлттэй 6, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилт 95,7 хувьтай байна.

**Гурав. Дүгнэлт**

1. Тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 195 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 100%-ийн биелэлттэй 136, 70%-ийн биелэлттэй 29, 30%-ийн биелэлттэй 30 арга хэмжээ байгаа ба гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт нь 84.8 хувьтай байна.
2. Цаашид гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ирүүлэхдээ тайлант хугацаанд хэрэгжсэн арга хэмжээнүүдийн үр нөлөөг товчоор дурьдаж оруулах.

**Дөрөв. Санал, Зөвлөмж**

1. Зам, тээврийн хөгжлийн сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 48,3 хувьтай буюу маш бага үзүүлэлттэй байгаад анхаарч, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.

**ТАНИЛЦСАН:**

САЙД Б.ЭНХ-АМГАЛАН

ДЭД САЙД Л.ХАЛТАР

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.БАТБОЛД

АВТОЗАМЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.ОРГИЛ-ЭРДЭНЭ

**ХЯНАСАН:**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.ЭНХБОЛД

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**

АВТО ЗАМЫН САЛБАРЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ГАНТӨМӨР

## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ АВТОЗАМЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2019 ОНЫ 4 ДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН НЭГДСЭН ДҮН

| № | Хяналтанд байх арга хэмжээ | 2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Үүнээс | | Дундаж хувь | Биелэлт /Хувиар/ | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/ | Тухайн улиралд тасарсан арга хэмжээ /Өссөн дүнгээр/ | | 100 | 90 | 70 | 50 | 40 | 30 | 10 | 0 | Хугацаа болоогүй | Үнэлэх боломжгүй |
| 1 | Үр дүнгийн гэрээний хэрэгжилт | 195 | 195 | - | **84,8** | 136 | | 29 | - | - | 30 | - | - | - | - |
| 2 | МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын биелэлт | | | - | **100** | 1 | - | - | - | - | - | - | - | - | - |
| 3 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт | 73 | 73 | - | **87.6** | 24 | - | 6 | - | 4 | - | - | - | - | 39 |
| 4 | Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт | 24 | 24 | - | **100** | 24 | - | - | - | - | - | - | - | - | 1 |
| 5 | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт | 78 | 78 | -- | **89.6** | 45 | - | 21 | - | - | 1 | - | - | 11 | - |
| 6 | Сайдын тушаалын биелэлт /Хүчингүй болсон-1 / | 74 | 74 | - | **83.0** | 43 | - | 13 | - | - | 9 | - | 1 | 5 | 3 |
| 7 | Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлт | 51 | 51 | - | **95,7** | 42 | - | 7 | - | - | - | - | - | 2 | - |
| 8 | ЗГ-ын хуралдаанд оруулах асуудлын төлөвлөгөөний биелэлт | 2 | 2 | - | **100** | 1 | - | - | - | - | - | - | - | 1 | - |
| 9 | Сайдын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөний биелэлт | 4 | 4 | - | **92,5** | 3 | - | 1 | - | - | - | - | - | - | - |
| 10 | Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт | 8 | 8 | - | **85,0** | 4 | - | 4 | - | - | - | - | - | - | - |
| 11 | Нийслэлийн Засаг даргатай байгуулсан “Санамж бичиг”-ийн биелэлт | 14 | 14 | 7 | **41,4** | 3 | - | 4 | - | - | - | - | 7 | - | - |
| 12 | Ил тод нээлттэй байдлын үнэлгээ | 7 | 7 | - | **95,7** | 6 | - | 1 | - | - | - | - | - | - | - |
| | **Нийт дүн** | **530** | **530** | **7** | **86.7** | **331** | **-** | **86** | **-** | **4** | **40** | **-** | **8** | **20** | **39** |

Зам, тээврийн хөгжлийн яамны АЗБХЗГ-ын үйл ажиллагаанд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 530 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 100%-ийн биелэлттэй 331, 70%-ийн биелэлттэй 86, 40%-ийн биелэлттэй 4, 30%-ийн биелэлттэй 40, тасарсан 8, хугацаа болоогүй 20, үнэлэх боломжгүй 39 арга хэмжээ байна. Хэрэгжилт **86.7** хувьтай байна.